



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2026/087/-НА-СТА-ТШЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2026 он</p> | <p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа</p> <p>Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn Аудитын менежер: М.Нарантуяа</p> <p>Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn Шинжлэн магадлахуй ЭЗШ Аудит ХХК Утас: 99197346 Цахим хаяг: info@shinjlenmagadlakhui-audit.mn</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|--|------------------------------|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | Error! Bookmark not defined. |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | Error! Bookmark not defined. |
| 4.1 Ерөнхий зүйл | Error! Bookmark not defined. |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | Error! Bookmark not defined. |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | Error! Bookmark not defined. |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | Error! Bookmark not defined. |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | Error! Bookmark not defined. |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | Error! Bookmark not defined. |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | Error! Bookmark not defined. |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ..... | 10 |
| 5.1 Зөвлөмж..... | 10 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 12 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2026.02.25 № 156

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аудитын явцад санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц, онцлон мэдээлэх шаардлагатай асуудал тогтоогдоогүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын явцад санхүүгийн тайланд хамгийн их ач холбогдолтой, аудитын явцад онцгой анхаарал шаардсан, материаллаг буруу илэрхийллийн өндөр эрсдэлтэй асуудал илрээгүй тул аудитын гол асуудал тодорхойлоогүй болно.

Бусад асуудлын хэсэг

Бусад асуудлын хэсэг

Аудиторын дүгнэлтэд өөрчлөлт оруулахгүйгээр мэдээлэхэд, тус аудитын хүрээнд санхүүгийн тайланд хавсаргасан үйл ажиллагааны тайлан, статистик мэдээлэлд аудитын баталгаа өгөөгүй бөгөөд эдгээр нь аудитын дүгнэлтийн хамрах хүрээнд хамаарахгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 145,311,462.43 | 78,157,549.33 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 66,768,589.02 | 12,048,261.33 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 66,768,589.02 | 12,048,261.33 |
| 3121 | Төгрөг | 66,768,589.02 | 12,048,261.33 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 66,768,589.02 | 12,048,261.33 |
| 33 | АВЛАГА | 3,169,285.41 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,169,285.41 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 75,373,588.00 | 66,109,288.00 |
| 351 | Түүхий эд материал | 994,900.00 | - |
| 35130 | Эм боох материал | 994,900.00 | - |
| 354 | Хангамжийн материал | 74,378,688.00 | 66,109,288.00 |
| 35460 | Хүнсний материал | 28,800.00 | 372,900.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 74,349,888.00 | 65,736,388.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 369,590,748.47 | 384,732,181.76 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 369,590,748.47 | 384,732,181.76 |
| 392 | Биет хөрөнгө | 350,994,748.47 | 366,821,181.76 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 362,186,761.00 | 362,186,761.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (45,005,319.00) | (52,506,210.28) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 45,967,320.50 | 53,060,120.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (24,374,834.35) | (28,363,276.27) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 35,892,004.00 | 27,639,130.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (24,216,866.88) | (10,100,544.41) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 21,857,500.00 | 14,635,250.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (21,857,500.00) | (275,731.98) |
| 39217 | Ном | 545,683.20 | 545,683.20 |
| 393 | Биет бус хөрөнгө | 18,596,000.00 | 17,911,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,885,000.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,185,000.00) | (1,485,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 17,896,000.00 | 17,896,000.00 |
| 3 | <u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</u> | <u>514,902,210.90</u> | <u>462,889,731.09</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 5,438,625.25 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 5,438,625.25 | - |
| 413 | Өглөг | 5,438,625.25 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 3,654,120.25 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 506,055.00 | - |
| 4136 | Бусад өглөг | 1,278,450.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,278,450.00 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 509,463,585.65 | 462,889,731.09 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 509,463,585.65 | 462,889,731.09 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 213,838,744.15 | 213,838,744.15 |
| 51101 | Өмч: - төрийн | 213,838,744.15 | 213,838,744.15 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 243,722,239.78 | 197,148,385.78 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 242,954,839.35 | 243,722,239.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 767,400.43 | (46,573,854.56) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 51,902,601.72 | 51,902,601.72 |
| 6 | <u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</u> | <u>514,902,210.90</u> | <u>462,889,731.09</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 666,498,000.00 | 781,058,374.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 33,669,574.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 33,669,574.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 32,228,624.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 1,440,950.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 666,498,000.00 | 747,388,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 577,795,300.00 | 662,548,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 577,795,300.00 | 662,548,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 5,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,000,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 88,702,700.00 | 79,840,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 88,702,700.00 | 79,840,800.00 |
| 2 | <u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</u> | <u>665,730,599.57</u> | <u>827,231,962.06</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 665,730,599.57 | 827,231,962.06 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 665,610,337.21 | 826,916,264.28 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 458,718,728.87 | 574,882,690.10 |
| 210101 | Үндсэн цалин | 315,650,197.32 | 373,657,291.97 |
| 210102 | Нэмэгдэл | 130,671,007.40 | 165,966,409.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 18,016,024.00 |
| 210104 | Урамшуулал | 12,397,524.15 | 17,242,965.03 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50,215,199.39 | 71,210,862.75 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,469,628.93 | 47,815,099.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,011,120.32 | 6,882,001.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,995,660.29 | 2,864,031.56 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,920,968.62 | 2,938,258.07 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,817,821.23 | 10,711,472.53 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 44,582,437.64 | 60,525,102.22 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,500,000.00 | 5,844,685.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,276,000.00 | 50,450,081.22 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,806,437.64 | 4,230,336.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 15,596,750.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 15,596,750.00 |
| 2105 | Нормативт зардал | 49,403,603.05 | 48,411,285.00 |
| 210502 | Хоол, хүнс | 49,403,603.05 | 48,411,285.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 22,502,600.00 | 18,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,502,600.00 | 18,600,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,025,600.00 | 1,172,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,025,600.00 | 1,172,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,162,168.26 | 36,517,374.21 |

| | | | |
|----------|--|--------------------------|-------------------------------|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,911,595.00 | 8,384,950.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,093,650.00 | 4,219,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,156,923.26 | 23,621,264.21 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 120,262.36 | 315,697.78 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 120,262.36 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 120,262.36 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 315,697.78 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 315,697.78 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 767,400.43 | (46,173,588.06) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 400,266.50 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 400,266.50 |
| <u>4</u> | <u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</u> | = | <u>(400,266.50)</u> |
| <u>5</u> | <u>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</u> | <u>767,400.43</u> | <u>(46,573,854.56)</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 666,498,000.00 | 747,458,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 666,498,000.00 | 747,458,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 577,795,300.00 | 662,548,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 577,795,300.00 | 662,548,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 5,070,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 70,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 88,702,700.00 | 79,840,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 88,702,700.00 | 79,840,800.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 669,358,028.42 | 794,953,027.69 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 669,358,028.42 | 794,953,027.69 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 669,237,766.06 | 794,637,329.91 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 458,233,894.03 | 579,017,307.94 |
| 210101 | Үндсэн цалин | 315,165,362.48 | 377,791,909.81 |
| 210102 | Нэмэгдэл | 130,671,007.40 | 165,966,409.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 18,016,024.00 |
| 210104 | Урамшуулал | 12,397,524.15 | 17,242,965.03 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50,215,199.39 | 67,561,079.75 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,469,628.93 | 45,646,539.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,011,120.32 | 5,654,335.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,995,660.29 | 2,610,474.02 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,920,968.62 | 2,938,258.07 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,817,821.23 | 10,711,472.53 |

| | | | |
|-------------|---|-----------------------------|-----------------------------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 44,582,437.64 | 60,525,102.22 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,500,000.00 | 5,844,685.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,276,000.00 | 50,450,081.22 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,806,437.64 | 4,230,336.00 |
| 2105 | Нормативт зардал | 48,114,970.00 | 49,261,440.00 |
| 210502 | Хоол, хүнс | 48,114,970.00 | 49,261,440.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 44,000,000.00 | 19,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,000,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 34,000,000.00 | 19,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,658,000.00 | 2,039,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,658,000.00 | 2,039,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,433,265.00 | 17,232,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,001,665.00 | 12,490,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,431,600.00 | 4,742,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 120,262.36 | 315,697.78 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 120,262.36 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 120,262.36 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 315,697.78 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 315,697.78 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (2,860,028.42) | (47,494,227.69) |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 4,360,000.00 | 7,226,100.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4,360,000.00 | 7,226,100.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4,360,000.00 | 7,226,100.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,360,000.00 | 7,226,100.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (4,360,000.00) | (7,226,100.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (7,220,028.42) | (54,720,327.69) |
| 9 | <u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u> | <u>73,988,617.44</u> | <u>66,768,589.02</u> |
| 10 | <u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u> | <u>66,768,589.02</u> | <u>12,048,261.33</u> |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|-------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 213,838,744.15 | 51,902,601.72 | 242,954,839.35 | 508,696,185.22 |

| | | | | | |
|------------|--|-----------------------|----------------------|-----------------------|-----------------------|
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 213,838,744.15 | 51,902,601.72 | 242,954,839.35 | 508,696,185.22 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 767,400.43 | 767,400.43 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 213,838,744.15 | 51,902,601.72 | 243,722,239.78 | 509,463,585.65 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 213,838,744.15 | 51,902,601.72 | 243,722,239.78 | 509,463,585.65 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 213,838,744.15 | 51,902,601.72 | 243,722,239.78 | 509,463,585.65 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (46,573,854.56) | (46,573,854.56) |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 213,838,744.15 | 51,902,601.72 | 197,148,385.22 | 462,889,731.09 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|-----------------------|---|----------------|----------------|-----------------|--------|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүнгээр | Хувь |
| 12200 | ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 743,120,200.00 | 742,073,102.22 | 1,047,097.78 | 99.86 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 743,120,200.00 | 742,073,102.22 | 1,047,097.78 | 99.86 |
| 12000 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.00 |
| 120010 | Туслах үйл ажиллагааны орлого | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.00 |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 748,120,200.00 | 747,073,102.22 | 1,047,097.78 | 99.86 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 811,219,900.00 | 801,793,429.91 | 9,426,470.09 | 98.84 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 811,219,900.00 | 801,793,429.91 | 9,426,470.09 | 98.84 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 580,077,100.00 | 579,017,307.94 | 1,059,792.06 | 99.82 |
| 210101 | Үндсэн цалин | 403,380,600.00 | 377,791,909.81 | 25,588,690.19 | 93.66 |
| 210102 | Нэмэгдэл | 164,159,800.00 | 165,966,409.10 | (1,806,609.10) | 101.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 18,016,024.00 | (18,016,024.00) | - |
| 210104 | Урамшуулал | 12,536,700.00 | 17,242,965.03 | (4,706,265.03) | 137.54 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 72,153,200.00 | 67,561,079.75 | 4,592,120.25 | 93.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,950,200.00 | 45,646,539.93 | 3,303,660.07 | 93.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,800,800.00 | 5,654,335.20 | 146,464.80 | 97.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,900,300.00 | 2,827,217.70 | 73,082.30 | 97.48 |

| | | | | | |
|-------------|---|-----------------------------|-----------------------------|--------------|--------|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,900,300.00 | 2,721,514.39 | 178,785.61 | 93.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,601,600.00 | 10,711,472.53 | 890,127.47 | 92.33 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 61,005,200.00 | 60,525,102.22 | 480,097.78 | 99.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,914,400.00 | 5,844,685.00 | 69,715.00 | 98.82 |
| 210302 | Түлш, халаалт | 51,276,000.00 | 50,005,540.42 | 1,270,459.58 | 97.52 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,814,800.00 | 4,674,876.80 | (860,076.80) | 122.55 |
| 2105 | Нормативт зардал | 52,406,300.00 | 49,261,440.00 | 3,144,860.00 | 94.00 |
| 210502 | Хоол, хүнс | 52,406,300.00 | 49,261,440.00 | 3,144,860.00 | 94.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 19,000,000.00 | 19,000,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,000,000.00 | 19,000,000.00 | - | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,566,900.00 | 2,566,900.00 | - | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,566,900.00 | 2,566,900.00 | - | 100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,011,200.00 | 23,861,600.00 | 149,600.00 | 99.38 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,268,700.00 | 19,119,100.00 | 149,600.00 | 99.22 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,742,500.00 | 4,742,500.00 | - | 100.00 |
| 4 | <u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u> | <u>66,768,589.02</u> | <u>66,768,589.02</u> | - | 100.00 |
| 5 | <u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u> | <u>12,048,261.33</u> | <u>12,048,261.33</u> | - | 100.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | - | 100.00 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт илэрсэн 1,282.26 мянган төгрөгийн алдаа зөрчилд санхүүгийн программ болон татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоололтой холбоотой зөрчилд зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аудитаар дараах 3 зөвлөмж өгсөн болно.

3.1.1. Цалингийн зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

3.1.1.1 Илрүүлэлт:

Хувь хүний орлогын албан татвар болон нийгмийн даатгалын тайланг тухайн оны 1-4 улиралд тайлагнасан дүн нь цалин хөлсний тооцооны хүснэгтээс 832.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь " Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" буюу 14.4.1. "аж ахуйн бүх

ажил, гүйлгээ” 14.4.4. "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр”, ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл тодруулгын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

3.1.1.1 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татвар болон нийгмийн даатгалын тайланг цалин хөлсний тооцооны хүснэгттэй тулган баталгаажуулж тайлагнах дотоод хяналтыг сайжруулж, зөрүүгийн шалтгааныг тогтоон холбогдох тайлангуудад засвар оруулж залруулах, цаашид цалин, татвар, шимтгэлийн бүртгэл–тайлангийн уялдаа хангах зорилгоор улирал тутам тулгалт хийж, баталгаажсан акт үйлдэн баримтжуулах, тайлан гаргахын өмнө ерөнхий нягтлан бодогчийн хяналтын давхар шалгалтын тогтолцоог хэвшүүлэх

3.1.2. Цалингийн зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

3.1.2.1 Илрүүлэлт:

Тайлант онд дараах саруудад 1, 2, 3, 4, 6 цалинг тооцоолохдоо нийгмийн даатгалын шимтгэлийн код алдаатай татагдснаас 449.71 мянган төгрөгөөр буруу тайлагнасан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” буюу 14.4.1. "аж ахуйн бүх ажил, гүйлгээ” 14.4.4. "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр” заалтуудтай нийцэхгүй, ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл тодруулгын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

3.1.2.1 Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тооцооны хуудсыг сар бүр цахимаар илгээж, албан хаагч нартай холбоотой орсон өөрчлөлтийг тухай бүрд нь цахимаар мэдээлэн, тооцоог тулган баталгаажуулж байх.

3.1.3.Санхүүгийн программ данстай холбоотой асуудал

3.2.3.1 Илрүүлэлт:

Бараа материалын зарлагыг зарцуулсан өдрөөр бус сарын сүүлээр зарлагадан санхүүгийн программд бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 26.2.Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл сууриар бүртгэж, тайлагнана, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө, 13.1' Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно' гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.3.1 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын орлого болон зарлагыг тухай бүрт нь программд бүртгэн бараа материалын зарцуулалтын тайланг үнэн зөв, цаг хугацаанд тайлагнах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 сарын 01 -ны дотор ирүүлэхийг анхаарна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----|----------|-----------------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Татвар болон нийгмийн даатгалын тайланг цалин хөлсний тооцооны хүснэгтээс зөрүүтэй | 1 | 832.55 | | | | | 1 | 832.55 | | | | |
| Нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн кодыг зарүүтэй тайлагнасан | 1 | 449.71 | | | | | 1 | 449.71 | | | | |
| Бараа материалын орлого, зарлага хийдэггүй ба бараа материалын зарцуулалтын тайлан гаргадаггүй. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Дүн | 3 | 1,282.26 | | | | | 3 | 1,282.26 | | | | |